



4. Хөгжингүй орнуудын тусгай тоноглогдсон тээврийн хэрэгслүүд нь өндөр үнэтэй, эдийн засгийн хувьд авч ашиглах боломжгүй гэж үзвэл Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, Тахарын алба нь дотоод нөөц боломжоо ашиглан зорчигч тээврийн автобус, ачааны автомашиныг орчин үеийн жишигт нийцүүлэн тоноглож үйл ажиллагаандаа ашиглах.
5. Хөгжингүй орнуудын хуяглан хүргэх ажиллагааны эрх зүйн зохицуулалт, техник, зохион байгуулалтыг судалж Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, Тахарын алба нь үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх гэсэн саналуудыг дэвшүүлж байна.

**О.ПҮРЭВСҮРЭН**

*Шүүхийн шийдвэр
гүйцэтгэлийн
сургуулийн Эрүүгийн
ял эдлүүлэх эрх зүйн
тэнхимийн багш,
ахлах дэслэгч*

НИЙГМИЙН АЖИЛ ДАХЬ МЭРГЭЖЛИЙН УДИРДЛАГААР ХАНГАХ ҮЙЛ ЯВЦ

Мэргэжлийн удирдлагын зорилго

Нийгмийн ажил дахь мэргэжлийн удирдлагаар хангах үйл явц нь нийгмийн ажилтнуудад өөрсдийн мэдлэг чадвараа дайчлан, ажлаа үр нөлөө үр ашигтай гүйцэтгэхэд нь туслах асуудалд анхаарлаа хандуулдаг. Мэргэжлийн удирдлагаар хангах гэдэг нь “ерөнхийд нь ажиглах, хяналт тавих, харгалзах” гэсэн утгыг агуулна.

Харин нийгмийн ажилд энэхүү ойлголт нь мэргэжлийн удирдагчийн / Supervisor/ нийгмийн ажилтантай буюу удирдуулж байгаа хүнтэй харилцах харилцаанд гүйцэтгэх үүргийг тодорхойлоход хэрэглэнэ. Мэргэжлийн удирдагч болон удирдлуулж байгаа хүний хоорондох харилцаа нь ажилтны чадамжийг нэмэгдүүлэхэд чиглэнэ. Мэргэжлийн удирдлагаар хангах гэдэг нь боловсролын, удирдлагын болон боломж олгох чиглэлээр заах-сурах үйл явдал юм.

Мэргэжлийн удирдлагаар хангах үйл явцыг бүлгийн болон ганцаарчилсан хэлбэрээр зохион байгуулж болно. Мэргэжлийн удирдагчийн үүрэг бол



ажилтнууд ялангуяа шинэ туршлагагүй ажилтнуудад тусламж дэмжлэг үзүүлэх, идэвхижүүлэх, тэдэнд мэдээлэл дамжуулах, тэднийг сонсох явдал байдаг.

Чадварлаг мэргэжлийн удирдагч нь ажилтны мэдэхгүй байгаа ур чадвар нь дутагдаж байгаа зүйлсийг зааж хэлж өгөхөөс гадна өөрийн санаа оноогоо тусгах нь хянахад тэдэнд тус дэм болж өгдөг. Мөн ажилтны санаа зовсон, түгшүүртэй байдлыг хөнгөвчилж, тэднийг ойлгож, ажлыг нь сонирхох зэргээр тусламж дэмжлэг үзүүлдэг. Мэргэжлийн удирдагчид нь шинэ ажилтнуудад мэргэжилтний хувьд үлгэр дууриалал болох төдийгүй өөр байгууллагаас ирсэн туршлагатай ажилтнуудыг байгууллагатай холбож өгөх гүүр нь болдог.

Мэргэжлийн удирдлагаар хангах үйл явц нь гурван гол үйл ажиллагаанаас бүрдэнэ.

1. *Зааж сургах*
2. *Удирдан зохион байгуулах*
3. *Боломж олгох*

1. *Зааж сургах* үйл явц нь шинэ нийгмийн ажилтнуудын мэргэжлийн хандлагыг улам гүнзгийрүүлж төлөвшүүлэх тал дээр тэдний ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлэхэд туслахад чиглэгдэнэ. Энэ нь нийгмийн ажлын практик чадварыг нэмэгдүүлэх, хөгжүүлэхэд шинэ ажилтнуудад туслах асуудалтай нягт холбоотой. Шинэ нийгмийн ажилтнууд ихэнхдээ ажиллах явцдаа суралцдаг бөгөөд дараа нь хоорондоо юу нь сайн байсан болон юу нь хэцүү байсан талаар хэлэлцэнэ.

Супервайзер нь нийгмийн ажлын багш, мэргэжилтэн, зөвлөхүүдийн нэгэн

адилаар нийгмийн ажлын практикийн сэтгэлийн дарамттай байдаг өвөрмөц чанар болон “практикийн ажилтнуудад горьдлого тасрах тохиолдол цөөнгүй” байдаг болохыг сайтар ойлгох хэрэгтэй.

Мэргэжлийн удирдлагаар хангах үйл явц, практикийн хичээлүүд болон ажлын байран дахь сургалтуудыг явуулахдаа анхаарвал зохих дараах таван хүрээг тодорхойлдог. Үүнд:

а. Ажилтнуудад үйлчлүүлэгчийн бага боловч амжилтыг илрүүлэн, сайшаан урамшуулахын хажуугаар өөрсдийн ажлаа бодит, хэрэгжихүйц зорилгыг дэвшүүлэхэд нь тусгах.

б. Эерэг хэм хэмжээг хөгжүүлэх, хязгааруудыг тогтоох.

в. Хувь хүн, нээлттэй бүлэг болон байнгын бус ирцтэй бүлэгтэй ажиллах.

г. Ялгаатай байдал болон зөрчлийг, ялангуяа ялгаварлан гадуурхах явдлаас үүдэлтэй зөрчлийг зохицуулах.

д. Үйлчлүүлэгчдэд өөрсдийн мэдрэмж, бодол санаагаа илэрхийлэх, бусадтай хамтран ажиллахад нь туслахуйц үйл ажиллагаануудыг ашиглах.

2. *Удирдан зохион байгуулах* үйл явцын хүрээнд мэргэжлийн удирдагч/ супервайзер нь шинэ нийгмийн ажилтнуудыг удирдан чиглүүлэхээс гадна цалин хөлс олгох, албан тушаал дэвшүүлэх, ажлыг хувиарлах, баг зөвлөлүүдэд оруулж ажиллуулах гэх мэт менежментийн үйл ажиллагаанд тусалцаа үзүүлдэг. Супервайзер нь нийгмийн ажилтнуудын ажлын чанарын болон тоон үзүүлэлтүүдийг нэгэн жигд байлгахад анхааран ажиллана.

3. *Боломж олгох үйл явц* нь



удирдлагадаа байгаа хүмүүсийнхээ ажлыг идэвхижүүлж, нийгмийн үйлчилгээг хүргэхэд өөрдсийн хийх ёстой зүйлээ хийхэд нь туслах юм. Энэ нь тэдэнд ур чадвар чадамжаа ашиглах үед хаалгыг нээж өгсөн явдал юм. Байгууллагын уур амьсгал ба боломж олгох үйл явц нь нийгмийн үйлчилгээний байгууллагын эцсийн үр дүнд хэрхэн нөлөөлдөгийг судалхад мэргэжлийн удирдагч/супервейзерууд нь байгууллагын уур амьсгал зөөлрүүлэгч, сөрөг нөлөөнөөс хамгаалагчийн үүрэг гүйцэтгэдэг бөгөөд шинэ нийгмийн ажилтнуудыг байгууллагын бүтцэд дасан зохицох боломж олгодог.

Мэргэжлийн удирдлагаар хангах асуудал нь байгууллагын үйл ажиллагаа, удирдлагын бүтцийн чухал хэсэгт тооцогддог. Байгууллагын хувьд шинээр ажилд орж байгаа хүмүүст мэргэжлийн удирдлагын үйл явц чухал байдлаар тавигддаг. Ерөнхийдөө энэхүү үйл явцын зарим төрлүүд албан, албан бус хэлбэрээр эсвэл аль алинаар нь зохион байгуулагдаж байгаа бөгөөд энэ нь байгууллагын ажилтнуудын чадамжийг хөгжүүлэхэд хамгийн тустай, үр нөлөөтэй хөтөбөрүүдийг санал болгодог. Өөрөөр хэлбэл мэргэжлийн удирдлагаар хангах үйл явцыг хэт их, эсвэл хэт бага байлгахад анхаарах биш харин шаардлагатай цаг үед, шаардлагатай ажилтанд хангалттай чухал ач холбогдолтой байхтай холбоотой юм.

Мэргэжлийн сайн удирдагчийн шинэ чанарууд

Сайн мэргэжлийн удирдагч нь дараах хэд хэдэн шинэ чанарыг агуулсан байна. Үүнд:

- Нийгмийн ажлын мэдлэгтэй байх
- Практик чадвартай байх

- Нээлттэй хаалганы бодлого баримтладаг байх
- Амлалт
- Илэн далангүй байх
- Талархал илэрхийлэх болон магтаал, сайшаал хэлэх

Мэргэжлийн удирдлагаар хангах үйл явцын үндсэн зарчмууд

Нийгмийн ажил дахь мэргэжлийн удирдагчийн баримтлах үндсэн зарчмыг дараах байдлаар тодорхойлно.

1. Нийгмийн ажлын мэргэжлийн удирдагч нь байгууллага болон үзүүлж буй үйлчилгээний талаархи ур чадвар, зарчмуудыг зааж сургах, дараагийн шатанд удирдуулж буй хүмүүст өөрийн үйл ажиллагааг удирдах зөвшөөрөл олгох

2. Мэргэжлийн удирдагчийн заасан мэдлэг, зарчмуудтай нийцсэн зорилго, зорилтуудыг томьёолон хэрэгжүүлэх замаар нийгмийн ажилтнууд өөрсдийгөө удирдах

3. Мэргэжлийн шаардлагатай үед дуирдагчид нь нийгмийн ажилтнуудад туслахуйц, түүнчлэн сургах, сурах үйл явцыг тасралтгүй явуулахаар бэлтгэгдсэн байх

4. Нийгмийн ажилтнууд шаардлагатай үед мэргэжлийн удирдагчаас тусламж хүсэх

5. Нийгмийн ажилтнууд өөрийн мэргэжлийн удирдагчдад үйл ажиллагаагаа тайлагнах ирээдүйн зорилгыг хамтран дэвшүүлэх

Мэргэжлийн удирдлагын хангах үйл явцын бүрэлдэхүүн хэсгүүд:

1. Хувийн болон бүлгийн зорилго, хуваарилалт, хэрэгжилт



2. Хамтын шийдвэр гаргах үйл явцыг хэрэгжүүлэх
3. Бүлгийн үйл явцыг чиглүүлэх
4. Ажлын төлөвлөлт, менежмент хийх
5. Харилцаа, сүлжээг хөгжүүлэх
6. Гүйцэтгэлийг үнэлэх
7. Нийгмийн ажилтнуудыг идэвхижүүлэх
8. Кейс дээр зөвлөлдөх мэргэжлийн дэмжлэг үзүүлэх
9. Нийгмийн ажилтан болон үйлчлүүлэгчийн эрх ашгийн нөлөөлөл хийх
10. Зөрчлийг зохицуулах
11. Төлөвлөгөөт өөрчлөлт хийх

Мэргэжлийн удирдлагаар хангах үйл явцын загварууд

Мэргэжлийн удирдлагаар хангах үйл явцын олон төрлүүд байдаг. Зарим байгууллагууд тэдгээрээс олон төрлийг хэрэглэдэг байхад тодорхой хэсэг нь зөвхөн нэг л загварыг ашигладаг. Нийгмийн ажлын практикт мэргэжлийн удирдлагаар хангах үйл явцын 6 загварыг тодорхойлсон байдаг. Үүнд:

1. **Давтлагын загвар:** Ганцаарчилсан харилцаанд мэргэжлийн удирдагч болон удирдуулж буй хүн ордог.
2. **Зөвлөгөөний загвар:** Энэхүү загвар нь нийгмийн ажилтан болон мэргэжлийн удирдагч хоёр ганцаарчилсан хэлбэрээр эсвэл байгууллагын бусад ажилтнуудтай хамтран ажилтнуудын сурах үйл явцыг нэмэгдүүлдэг. Байгууллагын үйл ажиллагаанд ажилтнуудын оруулж буй хувь нэмрийг өсгөх, эсвэл дээрх зорилтуудыг аль алиныг нь хамарсан байдлаар ажилладаг.
3. **Мэргэжлийн удирдагчийн бүлгийн загвар:** Энэхүү загвар

нь мэргэжлийн удирдагч болон түүнээр удирдуулж буй хүмүүсийн бүлэг бөгөөд давтлагын загварын өргөжүүлсэн хэлбэр гэж үздэг.

4. **Нэг түвшний бүлгийн мэргэжлийн удирдлагаар хангах загвар:** Энэ загварт мэргэжлийн удирдагч гэж байдаггүй бөгөөд бүлгийн бүх гишүүд ижилхэн оролцдог.
5. **Хоёр гишүүн бүхий бүлгийн мэргэжлийн удирдлагаар хангах загвар:** Энэхүү загвар нь нэг түвшний бүлгийн загвараас хөгжсөн бөгөөд хоёр ажилтан харилцан бие биедээ мэргэжлийн удирдагч болдог.
6. **Багаар ажиллах загвар:** Хэлэлцэх асуудал нь багийн гишүүдийн амжилтанд чиглэгдэх бөгөөд хэлэлцүүлэг нь ижил түвшний харилцаагаар явагддаг загвар юм.

Мэргэжлийн удирдлагаар хангах үйл явцыг сайжруулах нь

Нийгмийн ажлын мэргэжлийн удирдлагаар хангах үйл явц дахь нэг чухал асуудалд шаардлагатай сургалтанд хамрагдсан мэргэжлийн удирдагч цөөхөн байгаа явдал байдаг. Иймээс мэргэжлийн удирдлагаар хангах үйл явцын боловсролын төлөвлөлтийг нэмэгдүүлэх явдал юм. Нийгмийн ажлын болон бусад сургуулиуд мэргэжлийн удирдагчийн тусгай сургалтын хөтөлбөрийг боловсруулан сонсогч, оюутнуудад мэргэжлийн удирдагчийн хэрэглэгдэх мэдлэг, ур чадвар, үнэт зүйлсийг олгох, практикт ажиллаж буй нийгмийн ажилтнуудыг тусгайлан сургах шаардлагатай байна. Энэ нь мэргэжлийн удирдлагын хоёр талын бүхий л явцад үр бүтээлтэйгээр оролцох явдлыг сайжруулж байгаа илрэл болно.